




ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ ᠰᠤᠲᠢᠰᠲᠢᠬᠢᠶᠢᠨ ᠬᠡᠯᠲᠡᠰ



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД 2017 ОН

Хүн амын нас, хүйсийн суварга Population pyramid of Govi-Altai




2017 оны эцэст манай аймгийн хүн 57441 байна. Нийт хүн амыг нас хүйсийн суваргаас харахад 0-39 насны хүн амд эрэгтэйчүүдийн эзлэх хувь илүү байхад 40-с дээш насныханд эмэгтэйчүүдийн эзлэх хувь их байна. Аймгийн хэмжээнд 70 дээш насны 1464 өндөр настан байгаагийн 65.9 хувь нь эмэгтэйчүүд байна. 2017 оны эцсээр аймгийн хэмжээнд 97-с дээш насны 6 өндөр настан байгаа бөгөөд 5 эмэгтэй хүн байна




ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠯᠤᠯᠤᠰ ᠰᠤᠲᠢᠰᠲᠢᠬᠡᠢ ᠬᠡᠯᠲᠡᠰ

Хүн амын тоо, байршаар 2017 он



Аймгийн төвд 5128 өрхийн 17618 хүн, сумын төвд 3784 өрхийн 13186 хүн, тосгонд 277 өрхийн 902 хүн амьдарч байна. Хөдөөд 7305 өрхийн 25735 хүн амьдарч байгаа нь нийт хүн амын 44.8 % байна.


Хүн ам байршлаар, эмэгтэйчүүдийн эзлэх хувь






ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠯᠤᠯᠤᠰ ᠰᠤᠲᠢᠰᠲᠢᠬᠢᠶᠢᠨ ᠬᠡᠯᠲᠡᠰ

ХҮН АМ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТ – Эрүүл мэнд



Халдварт өвчнөөр өвчлөгчид, жил бүрийн эхний 12 сарын байдлаар




Аймгийн хэмжээнд 2017 оны эцэст 1216 эх амаржиж, амьд төрсөн хүүхэд 1221 болж, өнгөрсөн оны мөн үеийнхээс амаржсан эх 40 буюу 3.4 хувиар, хүүхэд 45-оор буюу 3.8 хувиар тус тус өссөн байна. Нялхасын эндэгдэл 20 болж, өмнөх оны мөн үеийнхээс 1 буюу 5.3 хувиар өсч, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 4 тохиолдол бүртгэгдэж өмнөх оны мөн үеийнхээс 1 тохиолдлоор буурсан байна. 1000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдэл 16.4 болж, өнгөрсөн оны мөн үеийнхээс 0.2 пунктээр өссөн, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 19.7 болж, өнгөрсөн оны мөн үеийнхээс 0.7 пунктээр өссөн байна. Халдварт өвчнөөр өвчлөгчид 2017 оны эцэст 785 болж, өнгөрсөн мөн үеийнхээс 179 буюу 18.6 хувиар буурчээ. Халдварт өвчлөл буурахад улаан бурханаар өвчлөгчид өнгөрсөн оны мөн үеэс 636 буюу 100 хувиар буурсан нь голлон нөлөөлсөн байна.




ᠬᠤᠨ ᠠᠮ, ᠨᠢᠶᠭᠮᠢᠶᠢᠨ ᠤᠵᠢᠭᠦᠯᠡᠯᠲ - ᠪᠣᠯᠣᠪᠰᠣᠷᠣᠯ

ХҮН АМ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТ – Боловсрол


Ерөнхий боловсролын сургуульд өдрөөр суралцагчид, жил бүрийн хичээлийн жилд




Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад хамрагдсан хүүхдүүд, жил бүрийн хичээлийн жилд



Ерөнхий боловсролын сургуулийн багш, жил бүрийн хичээлийн жилд



Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын үндсэн багш, жил бүрийн хичээлийн жилд




Ерөнхий боловсролын 28 сургууль, 29 цэцэрлэгт өсвөр үеийг сурган хүмүүжүүлж байна. ЕБСургуулиудад 11.4 мянган сурагч суралцаж, цэцэрлэгт 4.6 мянган хүүхэд хүмүүжиж байна. Энэ хичээлийн жилд нэгдүгээр ангид 1160 хүүхэд элсэн суралцаж байна.




ХҮН АМ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТ – Нийгмийн зарим үзүүлэлт


Бүтэн, хагас өнчин хүүхдийн тоо, жил бүрийн эцсийн байдлаар



Өрх толгойлсон эхийн тоо, жил бүрийн эцсийн байдлаар



Хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо, жил бүрийн эцсийн байдлаар




Хөгжлийн

бэрхшээлтэй хүмүүсийн 24.4 хувь нь хөдөлгөөний согогтой, 10.1 хувь нь сонсгол, 4.1 хувь нь хэл ярианы согогтой, 5.5 хувь нь хавсарсан согогтой, 11.8 хувь нь харах эрхтний өөрчлөлттэй, 27.5 хувь нь бусад, 16.6 хувь нь сэтгэцийн эмгэгтэй хүмүүс байна.


ᠬᠤᠨ ᠠᠮ, ᠨᠢᠶᠭᠮᠢᠶᠢᠨ ᠤᠵᠦᠭᠦᠯᠡᠯᠲᠤ – ᠨᠢᠶᠭᠮᠢᠶᠢᠨ ᠵᠠᠷᠢᠮ ᠤᠵᠦᠭᠦᠯᠡᠯᠲᠤ

ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ – Хөдөө аж ахуй


Хураасан үр тариа, жил бүрийн эцэст, тн




Хураасан төмс, хүнсний ногоо жил бүрийн эцэст, тн



Хураасан тэжээлийн ургамал, жил бүрийн эцэст, тн



Бэлтгэсэн өвс, гар тэжээл, жил бүрийн эцэст, тн




ᠡᠳᠢᠶ᠋ᠢᠨ ᠵᠠᠰᠭᠢᠶ᠋ᠢᠨ ᠤᠵᠦᠭᠦᠯᠡᠯᠲᠤ – ᠬᠥᠳᠡᠭᠡ ᠠᠵᠤ ᠶ᠋ᠢᠰᠤ



МАЛ ТООЛЛОГЫН 2017 ОНЫ ДҮН


2017.01.08

<http://www.govi-altai.nso.mn/>



**Говь-Алтай
аймаг 2017
оны жилийн
эцсийн мал
тооллогоор
3801651
толгой мал
тоолуулж
өмнөх оноос
304159 толгой
буюу 8.7
хувиар өслөө.**

Малын тоо 1940-2017 он мян.толгой




Малын тоо 2017 онд 66.2 сая толгой болж, хамгийн дээд хэмжээндээ хүрлээ.

Малын тоо 5 төрөл дээр өсөв



МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ – Төсөв

Төсвийн орлогын бүтэц хувиар 2017 оны XII сард



Төсвийн орлого


Орон нутгийн төсөвт 7 тэрбум 242.2 сая төгрөгийн орлого оруулж, төлөвлөгөө 112.0 хувиар, үүнээс татварын орлого 6 тэрбум 653.4 сая төгрөгийн орлого оруулж, төлөвлөгөө 113.4 хувиар, татварын бус орлого 542.1 сая төгрөгийн орлого оруулж, төлөвлөгөө 96.9 хувийн тус тус биелэлттэй байна. Улсын болон орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг Алтай, Баян-Уул, Бигэр, Бугат, Дарив, Дэлгэр, Жаргалан, Тайшир, Тонхил, Төгрөг, Халиун, Хөхморьт, Цогт, Цээл, Чандмань, Шарга Эрдэнэ, сумууд 104.6-182.0 хувиар давуулан биелүүлж, Есөнбулаг сум 2.4 хувиар тасалсан байна.



ᠮᠠᠬᠤᠷ᠎ᠠ ᠡᠳᠢ ᠵᠠᠰᠭᠢ ᠶ᠋ᠢᠵᠡᠭᠡᠯᠡᠲᠦ – ᠲᠥᠰᠡᠪ

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ – Төсөв

Орон нутгийн зарлага санхүүжилт түүний эзлэх хувь




Төсвийн зарлага

Орон нутгийн төсвийн зарлага санхүүжилтийн 97.3 хувийг санхүүжүүлэв. Үүнд цалин хөлс нэмэгдэл урамшууллын төлөвлөгөөний 99.5, ажил олгогчоос нийгмийн даатгалын шимтгэлийн 99.0, бараа үйлчилгээний бусад зардлын 99.7, зардал санхүүжилтын их үүсвэр 98.8 хувийг тус тус санхүүжүүлсэн байна. Орон нутгийн төсвийн байгууллагууд 65.0 сая төгрөгийн авлагатай, 10.0 сая төгрөгийн өглөгтэй ажиллажээ.



ᠮᠠᠻᠤᠷ᠎ᠠ ᠡᠳᠢᠶ᠋ᠢᠨ ᠵᠠᠰᠭᠢᠨ ᠤᠵᠢᠭᠦᠯᠡᠯᠲᠤ – ᠲᠥᠰᠥᠪ


МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ – Төсөв

БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖИЛ,
аймгаар улирлын дүн сая төгрөгөөр**Барилга**


Барилга угсралт, их засварын 9 тэрбум 861.8 сая төгрөгийн ажил хийж, үүнээс 9 тэрбум 233.3 сая төгрөгийн шинэ барилга өргөтгөл шинэчлэлт, 628.5 сая төгрөгийн барилга, замын их засварын ажлыг гүйцэтгэсэн байна.

2017 ОНЫ АЙМГИЙН ХАРИЛЦАА ХОЛБООНЫ САЛБАРЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

Харилцаа холбооны үйлчилгээний орлого мян.төг



Суурин утасны цэгийн тоо




Суурин телефон цэгийн тоо 576 холбоо ашиглалтын орлого 247.5 сая төгрөг, үүнээс хүн амаас орсон орлого 265.0 сая төгрөг болжээ. Интернетийн үйлчилгээний нэг цэгээр 16 суудалтай ажиллаж, интернетээр дунджаар 0.5 мянган хүнд үйлчилжээ.



ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠯᠤᠯᠤᠰ ᠰᠤᠲᠢᠰᠲᠢᠬᠡ ᠬᠡᠯᠲᠡᠰ

Гэмт хэрэг



Гэмт хэрэг: Байгууллага, иргэдийн 753.2 сая төгрөгийн өмч хөрөнгөнд хохирол учруулж, 200 гэмт хэрэг гарч, эдгээр хэргүүдээс танхай, хулгайн гэмт хэрэг, бусдын бие махбодид гэмтэл учруулсан гэмт хэргүүд 77.5 хувийг, нийт хэргийн 61.5 хувь нь Есөнбулаг сумд гарсан хэрэг эзэлж байна. Баривчлагдсан хүний тоо 140, өмнөх оны мөн үеэс 122 хүн буюу 6 дахин, тээврийн хэрэгсэл жолоодох эрхээ хасуулсан хүний тоо 185, өмнөх онтой харьцуулахад 9 хүн буюу 4.9 хувиар өссөн байна.

ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ИНДЕКС, бүлгээр, 2015=100%


Бараа, үйлчилгээний бүлэг	Жин	<u>2017-11</u> 2015-12	<u>2017-11</u> 2016-11	<u>2017-11</u> 2016-12	<u>2017-11</u> 2016-10
Ерөнхий индекс	100	105.8	103.7	103.7	100.7
Хүнсний бараа, ундаа, ус	29.3	95.8	104.6	104.6	103.1
Согтууруулах ундаа, тамхи	3.2	104.3	102.1	102.1	100.0
Хувцас, бөс бараа, гутал	16.1	110.2	102.8	102.8	100.0
Орон сууц, ус, цахилгаан, түлш	12.3	109.1	101.8	101.8	102.1
Гэр ахуйн тавилга, бараа	4.7	112.3	106.2	106.2	100.1
Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ	3.6	106.2	105.8	105.8	100.0
Тээвэр	12.2	102.8	109.0	109.0	98.7
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	4.4	98.9	100.0	100.0	100.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	2.8	101.6	100.3	100.3	100.0
Боловсролын үйлчилгээ	4.7	126.4	100.0	100.0	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	2.6	110.4	108.1	108.1	100.0
Бусад бараа, үйлчилгээ	4.1	101.6	102.7	102.7	100.0

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс Говь-Алтай аймгийн хэмжээнд 2017 оны 12 дугаар сард өмнөх сараасаа 0.7 хувь, өмнөх оны жилийн эцсээс 3.7 хувь, суурь үеийнхээс 5.8 хувиар өссөн байна. Ерөнхий индекс 2017 оны 12 дугаар сард өмнөх сарынхаас 0.7 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа ус 3.1, орон сууц, ус, цахилгаан, түлш бүлгийн индекс 2.1 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

Хэрэглээний бараа үйлчилгээний үнэ 2017 оны 12 дугаар сард өмнөх оны жилийн эцсээс 3.7 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, ус 4.6, согтууруулах ундаа, тамхи 2.1, хувцас, бөс бараа, гутал 2.8, гэр ахуйн тавилга, бараа 6.2, эм тариа, эмнэлгийн үйлчилгээ 5.8 тээврийн салбарийн үнийн индекс 9.0, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрний үйлчилгээ бүлгийн индекс 8.1 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.




**Хэрэглээний үнийн индекс
(өмнөх оны 12 сар=100)**





ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ ᠰᠤᠲᠢᠰᠲᠢᠬᠢᠶᠢᠨ ᠬᠡᠯᠲᠡᠰ

Махны үнэ, 7 хоногоор, төг



Махны дундаж үнэ: 2018 оны 01-р сарын 10-ны байдлаар хонины махны үнэ өмнөх сарынхаас 20.8 хувь, ямааны махны үнэ 11.1 хувь, үхрийн мах 20.0 хувиар өссөн байна. 2018 оны 01-р сарын 10-ны байдлаар жижиглэнгээр 1 кг үхрийн цул мах 6000 төгрөг, хонины мах 4500 төгрөг, ямааны /ястай/ мах 3500 төгрөгийн үнэтэй байв.


Мөнгөний нийлүүлэлт /M2/ 2017 оны 12 дугаар сарын эцэст 79.7 тэрбум төгрөг болж, өмнөх сарынхаас 6.0 тэрбум төгрөг буюу 8.2 хувиар өсчээ.

Мөнгөний зарим үндсэн үзүүлэлт, сарын эцэст сая төг

Үзүүлэлт	2017-XI	2017-XII
	Мөнгөний нийлүүлэлт M2	73635.1
Сарын өөрчлөлт, хувиар	-0.4	8.2
Нийт хадгаламж	63122.1	66644.9
Сарын өөрчлөлт, хувиар	-0.5	5.6
Төгрөгийн хадгаламж	62928.7	66627.1
Сарын өөрчлөлт, хувиар	-0.4	5.9
Валютын хадгаламж	193.4	17.8
Сарын өөрчлөлт, хувиар	-28.1	-90.8



Чанаргүй зээл, сарын эцэст, сая төг



Чанаргүй зээл 2017 оны 12 дугаар сарын эцэст 1.2 тэрбум төгрөг болж өмнөх сараас 263.3 сая төгрөгөөр буурсан байна. Чанаргүй зээл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 1.2 хувийг эзэлж байна.